



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 31 өдөр

Дугаар А/114

Улаанбаатар хот

Налайх дүүргийн “Ачлал налайх”  
өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус  
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 2,948,053.90 (хоёр сая есөн зуун дөчин найман мянга тавин гурван төгрөг ерэн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Налайх дүүргийн “Ачлал налайх” өрхийн эрүүл мэндийн төв (А.Даваасүрэн)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 5 нэр төрлийн 2,227,653.90 (хоёр сая хоёр зуун хорин долоон мянга зургаан зуун тавин гурван төгрөг ерэн мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 3 нэр төрлийн 720,400.00 (долоон зуун хорин мянган дөрвөн зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг Налайх дүүргийн “Ачлал налайх” өрхийн эрүүл мэндийн төв (А.Даваасүрэн)-д, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150503172

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А.1214 дугаар тушаалын хавсралт

ДАНСНААС ХАСАХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Байгууллагын нэр: Налайх дүүргийн Ачлал налайх ЭМТ

Д/Д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	Байгууллагын үнийн санал	НӨХГ-мэргэжилтэний дүгнэлт	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр	
<b>Машин тоног төхөөрөмж</b>														
1	принтер ML-2165	9 жил	ш	1	129900	129900	129900	-		Устах	Устах	Устах	Татах	
2	Компьютер DISC	8 жил	ш	1	450000	450000	450000	-		Устах	Устах	Устах	Татах	
3	Компьютер SAMSUNG	14 жил	ш	1	699363	699363	699363	-		Устах	Устах	Устах	Устах	
4	Прожектор LSUS	13 жил	ш	1	724590.9	724590.9	724590.9	-		Устах	Устах	Устах	Устах	
5	Нярайн жин GIMA	11 жил	ш	1	140500	140500	140500	-		Устах	Устах	Устах	Татах	
<b>Машин тоног төхөөрөмжийн дүн</b>							<b>2144353.9</b>	<b>2144353.9</b>						
<b>Тавилга эд хогшил</b>														
1	Сандаал хар	10 жил	ш	2	36850	73700	73700	-	Ашиглах боломжгүй	Устах	Устах	Устах	Устах	
<b>Тавилга эд хогшлын дүн</b>							<b>73700</b>	<b>73700</b>						
<b>Программ хангамж</b>														
1	Санхүүгийн программ	12 жил	ш	1	290,000	290,000	290,000.00	-	Ашиглах боломжгүй	Устах	Устах	Устах	Устах	
2	Санхүүгийн программ	5 жил	ш	1	440,000	440,000	440,000.00	-		Устах	Устах	Устах	Устах	
<b>Программ хангамжийн дүн</b>							<b>730,000</b>	<b>730,000.00</b>						
<b>Нийт данснаас хасах хөрөнгийн дүн</b>							<b>2,948,053.90</b>	<b>2,948,053.90</b>						
Үүнээс: Худалдах хөрөнгө														
Ахлах хөрөнгө														
<b>Татан төвлүүлэх хөрөнгө</b>							<b>2,227,653.90</b>							
<b>НӨХГ- т төвлүүлэх /30%/</b>							<b>720,400.00</b>							